

МОНГОЛ БИЧИГ БА ОРОСЖИН БИЧГИЙН ЯЛГАА ХИЙГЭЭД  
МОНГОЛ ХЭЛНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Б. Даваасүрэн\*

Дэлхийн аливаа ард түмний бичгийн хэл, ярианы хэл хоорондоо зөрүүтэй буюу бичсэнээ өөрөөр дууддаг нь хууль. Тогтонги мөнх юм гэж хорвоо дээр үгүй тул хэл ч мөн өөрийн гэсэн дотоод хуулиндаа захирагдаж хувьсан өөрчилөгддөг нь жам. Гэхдээ цаг хугацааны хувьд ярианы хэл бичгийн хэлнээсээ түрүүлж хувьсдаг онцлогтой. Харин зорилгоор буруу бичээд, буруу бичсэнээ дагаж буруу дууддаг гажууд явдал манай монгол хэлэнд оросжин үсэг авснаас хойш буй болсоныг мэдсээр, шүүмжилсээр авч засахгүй өдий хүрлээ. Тэгвэл бид өнөөдөр бичиг ном сурах гээд бага сургуульд орж байгаа монгол балчир хүүхдүүдэд монгол хэлнийхээ дууддаг уугуул авиаг буруу тэмдэглэхээд түүнийгээ тайлж хэлэхэд ч хэцүү, хэлэхгүй байх ч хэцүү балчигт суусан хэвээр. Нэгэнт хэлшинжлэлээс гажуудсан, илт зохиомол юм болсон тул монгол хэлний багш, хэлшинжлэлийн эрдэмтэд хүртэл ард иргэдээсээ хагуухан үг сонсох энүүхэнд болжээ. Монгол бичигт энэ мэт үсгийн будлиан гардаг уу, одоо нэг харьцуулаад бодоод үзээрэй. Монгол хэлэнд хэлний үзүүрийн “н” авиаг  $\gamma / \tau$  үсэг, хэлний угийн “ng”  $\kappa$  авиаг үсгээр тус тус ялгаж тэмдэглэдэг гээд зааж байх зөв үү, эсвээс өмнө хойно хоёр өөр авиаг нэг дүрсээр буюу “н” үсгээр тэмдэглэдэг гэж заагаад ямар ч үндэслэлгүй зохиомол тайлбар дагуул болгох зөв үү?! Хэрхэн ялгаатай дуудагдах нь ядаж үсгээ харуут танигдаж баймаар.

Орос хэлэнд “хорошо, плохой” гэж бичээд “харашо, плахой” гэж дууддаг нь орос хэлний зөв бичихзүй, дуудахзүйтэй холбоотой. Орос хэлний өргөлтгүй үеийн “о” эгшиг авиаг “а” мэт дуудана гэсэн дүрэмтэй байдаг тул үгийн эхэн, дунд, адагт орсон “о” авиаг ижил хэлбэрээр бичихээс өөр аргагүй гэсэн үг юм. Монгол бичгийн хэл, ярианы хэлэнд ийм авианзүйн зөв бичих дүрэм огт таарахгүй. Энэ дүрэм бол орос хэлэндээ яв цав тохирдог. Ингээд бодвол бид монгол хэлэнд төдий л тохирохгүй шинэ үсэг бичиг авч, авахдаа монгол хэлнийхээ зүй тогтолд сайн нийцсэн зөв бичих дүрэм боловсруулаагүйгээс болж монголчуудын үсэг авиа хоёрын харьцаа, хэлбэр агуулгын зарчимыг гайхалтай харуулж чадсан бичиг үсгийн ололтоосоо олон алхам ухарчээ.

\* Монгол Улсын Их Сургууль, Монгол хэл, соёлын сургууль

Бичигт хэрэглэж буй үсгийн тоо олон, цөөн, хэлбэр нэг янз байдгаас бичгийн төгөлдөр чанар шалтгаалдаг, сурахад хялбар байдаг зарчимтай, хуультай юм бол өнөөдрийн хэрэглэж байгаа шинэ үсгийн цагаан толгой яагаад монгол хэлний наад захын хэрэгцээг хангаж чадахгүй байна вэ? Жишээлбэл, монгол бичиг үсэгт ялгаатай бичиж тэмдэглэдэг хэлний гүн угийн  $\text{ᠨ}$   $\text{ᠨ}$   $\text{ᠨ}$  хийгээд гүн бус угийн  $\text{ᠨ}$   $\text{ᠨ}$   $\text{ᠨ}$  авиаг ( $z$ ) үсгээр тэмдэглэдэг. Гэтэл холбоо үг бүтээгээгүй тохиолдолд чухам аль нь вэ гэдгийг таахад хэцүү юм. Жишээ нь: “багаар, аргаар” гэхэд урдах хойдох үгийн тусламжитай л зөв дуудаж ялгаж чадна. Харин монгол бичгээр энэ хоёр үгийг зөв дуудах бичихэд будлиан гарахгүй. Монгол бичгээр *bay-a*  $\text{ᠪᠠᠶᠠ}$  (хэлний гүн угийн), *bay*  $\text{ᠪᠠᠶ}$  (хэлний гүн бус угийн); *ary-a*  $\text{ᠠᠷᠢᠶᠠ}$  (хэлний гүн угийн), *aryu*  $\text{ᠠᠷᠢᠭᠤ}$  (хэлний гүн бус угийн) гэх мэтээр харуут зөв ялгаж дуудаж бичиж болдог. Энэ мэтчилэнгээр орчин цагийн монгол хэлний цагаан толгойд хэлний үзүүр ( $n$ ) – хэлний угийн ( $ng$ )-ийг “ $n$ ”, шүргэх ( $j$ ) – хамжин шүргэх ( $dj$ )-г “ $ж$ ”, хэлний ар ( $q$ ) – урагшилсан ( $k$ )-г “ $x$ ”, хэлний ар ( $y$ ) – урагшилсан ( $g$ )-г “ $z$ ” гэх мэтээр адил бус шинжтэй өөр өөр авиаг ижил үсгээр тэмдэглэснээс болж зөв бичихзүй, дуудахзүй гажуудахад хүрчээ. Гэтэл хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан түрэг хэлт үндэстэнүүд 1939 оноос эхлэн улс төрийн дарамт шахалтаар арга буюу бүгд орос үсэг дээр суурилсан үсэг бичиг зохиож хэрэглэх болсон. Тэдгээр түрэг үндэстэнүүдийн хэрэглэж байсан оросжин үсгийн цагаан толгойг үзвэл манай оросжин шинэ үсэгт ганц үсгээр хоёр өөр авиаг ялгалгүй нэг үсгээр тэмдэглэснийг салгаж өөр өөр үсэг оноосон байдаг. Өөрөөр хэлбэл, хэлний үзүүр ( $n$ ) – хэлний угийн ( $н$ ), шүргэх ( $ж$ ) – хамжин шүргэх ( $жс$ ), хэлний ар ( $x$ ) – урагшилсан ( $x$ ), хэлний ар ( $z$ ) – урагшилсан ( $z$ ) гэж хос болгосон нь угтаа түрэг гаралтай хэлний зөв бичихзүй, дуудахзүйд орос бичиг таарахгүйг гярхай ажигласны баталгаа. Хэрэв тухайн цаг үед ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан түрэг хэлтэнүүд ингэж дуудах авиагаа орос хэлний дуудагдах авианаас салгаж үсэг оноогоогүй байсансан бол өнөөдөр мөн л бидний адил байдалтай сууж байх байсан биз ээ. Гэхдээ түрэг хэлтэнүүд дээрх маягаар хос үсэг зохиосон нь нэг талын эх хэлээ эрэмдэглэхгүй гэсэн санаа, нөгөө талын хожим толгойгоо мэдэх цагт оросжин үсгийг халаад, үндэснийхээ бичиг үсэгт төвөггүй шилжихэд дөхөмтэй байжээ. Тиймээс л 1990 оны эхээр ЗХУ задрахад түрэг угсаатнууд салж биеэ даасан хийгээд тусгаар болмогцоо бүгд оросжин үсгийг шууд халсан түүхтэй. Гэтэл оросжин цагаан толгой монгол хэлэнд тохирдоггүйн дээр орчин цагийн монгол хэлний цагаан толгойд монгол хэлэнд огт байдаггүй орос хэлний цагаан толгойн 27-д байдаг  $\text{ц}$  үсэг одоо хир байдаг нь гайхалтай. Үүнийг юу гэж тайлбарлах ёстой вэ?!

Үгийн язгуур үндэсийн тухайд ч тэр энгийн наад захын жишээ авахад тайлбарлах боломжгүй болдог. Огт болдоггүйдээ ч биш хэлшинжлэлийн ухаанаар тайлбарлавал огт байж боломгүйд учир оршино. Жишээлбэл, шинэ бичигээр заах төлөөний нэр “Энэ” гэдгийн балархай эгшигийг бичдэг хирнээ “Тэр” гэхэд адил байранд буй балархай эгшигийг гээж бичдэг. Хэлшинжлэл үүнд ямар ч тайлбар хийх ёсгүй, албагүй учир энгийн иргэдэд албан хүчээр зохиомол дүрэм цээжлүүлсээр, аргацаасаар ирсэн. Гэтэл монгол хэл нугархай биш залгамал хэл шүү дээ. Орос хэлний *список* “жагсаалт” – *списки* “жагсаалтууд”, англи хэлний *тан* “хүн” – *мен* “хүмүүс” гэх мэтээр үгийн язгуур үндэст орсон эгшиг авиа гээгдэх эсвэл өөрчилөгдөх нугармал (*флексия*) үзэгдэл огт байхгүй. Ингээд бодвол заах төлөөний нэр нэг бол “энэ, тэрэ” эсвээс “эн, тэр” байх ёстой. Өөр хувилбар байхгүй. Хуучин цагт албан шаардалгаар болоод байсан бол одоо монгол хэлэнд таарахгүй бичиг үсэг хэрэглээд урагш явах тусам ирээдүйд засахад хэцүү байдалд орно. Үүнээ холбогдуулан нэгэн жишээ дурдаваас энэтхэг-

европ зүгийн төрөл хэлний “ав-, зөө-” гэдэг үгийн язгуурыг харьцуулан үзвээс самгар. *bharami*, анг. *bear*, орос: *беру*, герег: *phero*, лат. *fero* хэмээх үгсийн язгуур нь *be ~ phe ~ fe* гэх мэт хувилбартай байна. Гэтэл энэтхэг-европ зүгийн хэлнүүдэд үгийн сангийн үндсэн утга *be ~ phe ~ fe* язгуурт хадгалагдахаас гадна бас тухайн язгуур хийгээд бүтээврийн дунд байрладаг “осевая согласная” буюу “тэнхлэг гийгүүлэгч” -*r*- чухал үүрэгтэй байдаг буюу үгийн сангийн утгыг үгийн язгуурын хамт давхар тээж явдаг гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, энэтхэг-европ зүгийн хэлэнд үгийн язгуурт орсон авиа тогтвортой бус (жишээлбэл, орос хэлний *читать – чтение*, англи хэлний *write – wrote*) байдаг бол монгол хэл, цаашилбал нийт алтай овгийн хэлэнд язгуур ямагт тогтвортой байна. Тэгвэл монгол хэлний *хос, хоёр, холбоо, хоршоо* гэх мэт үгийн *хо-* язгуур нь үгсийн сангийн утга илэрхийлэх хамгийн бага, цаашид үл задрах утгат хэсэг бөгөөд *хо-* язгуураас хойш орсон бүтээвэр *-с, -р, -боо, -шоо* бол шинэ үг бүтээх дагавар болохоос дээрх энэтхэг-европ хэлнүүдэд буй тэнхлэг гийгүүлэгч *-r-* тэй адил үүрэг огт гүйцэтгэхгүй.

Үгийн язгуураа эвдэж бичдэг учир араас нь орох дагавараа эвдэж тааруулахад хүрнэ. Жишээлбэл, “*барил, барил, төрөл*” гэхэд үгийн адагт дэвсгэр “-л” байна гэж харагдахаас бус эхний үгэнд үйлээс үйл, дараагийн хоёрт үйлээс нэр үүсгэх адил дагавар залгагджээ хэмээн танихын аргагүй. Монгол бичгээр бол *barila, baril, törül* тодорхой бөгөөд ялгаатай. Тэгвэл магадгүй монгол бичгээр “*бөх, бөө*” гэх үгийг адил бичээд ялгаад ойлгоод байгаатай адил юм биш үү гэх байх. Ингэж хэлж ярьдаг жирийн байтугай хэлшинжлэлийн мэргэжилтэй хүн нэг хоёр тааралддаг. Ижил бичилгэтэй өөр дуудалгатай (*omogramma*) үг аль ч хэлэнд бий. Гэхдээ ямар нэг хэлний бүх үг тийм болно гээд бодоод үзвэл утгагүйтэй адил муйхраар дээрх маягаар ярьж хэлж нотлож болохгүй.

Кирилл үсгийн дүрэмд мэдээж үгийн язгуур үндэсээ эвдээд дагавараа эвдэж тааруулсан болохоор нөхцөлөө эвдэж тохируулахаас өөр аргагүй.

Орос бичиг үсэг авсан нь тусгаар Монгол, Халимаг-Монгол, Буриад-Монгол. Монгол хэлний дээр дурдсан бүх онцлогийг эвддэг буюу хамгийн муу нь халимаг, удаах байранд бид. Харин хэл аялгуундаа тохируулж зохиосон нь буриад. Тиймээс ч буриад хүүхдэд монгол бичиг заахад төвөггүй сураад байдаг нэг гол учир энэ. Энэ талаар: “*Харин ийм зүйл дээр Буриад нөхөд олон тохиолдолд монгол хэлнийхээ онцлогийг сайтар харгалзсан байдаг. Та буриад толгойтой ямар нэгэн толь бичиг аваад үзвэл, бидний буруу бичээд “зөв” гэж итгэдэг болсон өдий төдий үгийг тэргэ, урида, арад (түмэн), (гэрийн) арада... гэх зэргээр монгол хэлний зүй ёсны дагуу байгааг олж ядах юмгүй хялбараханаа харах болно*” (Ц.Шагдарсүрэн “Эх хэлээ эвдэхгүй юм сан” УБ., 2010, 81 х.) гэжээ. Ингээд бодоход нэг л хэлний гурван аялгуугаар хэлэлцдэг ястан гурван янзаар боловсруулж аваад ч шинэ үсэг нэмэр тус болсонгүй. Хойшид бүр даамжирна. Үүнээс гарах цорын ганц зам бол монгол бичиг үсгээ нийтээр хэрэглэх, төрийн тодотголтойгоор хязгаарлаад орхилгүй төрийн хэргийг хөтөлдөг бичиг болгох явдал.

Дэлхийн бичиг үсгийн түүхэнд үүссэн цагаасаа хойш голлон хэрэглэгдсээр буй бичиг үсгийн тоонд манай өмнөд хөршийн *дүрс бичиг*, хойт хөршийн *авиан бичиг* буюу *цагаан толгойтой үсэг* багтдагийг бид мэднэ. Бичих онцлог ба зарчимыг нь ч мэднэ.

Шинэ үсгээр “*хар*” гэж бичээд холбоо үг эсвэл өгүүлбэрт ямар гишүүний үүргээр орсонг нь мэдээгүй бол үйл хөдлөл, өнгө зүс, чимээ дуурайсан үгийн чухам алин болохыг тааж мэдэх арга үгүй. Монгол бичгээр дээрх үгийг гурван янзаар дүрс ялгаж бичдэгээ эргэн санавал заавал холбоо үг, өгүүлбэрт оруулаад байх шаардалгагүй харуут л дан хэлбэрээсээ танигддаг. Энэ мэтээр монгол бичгийн бичлэгийн хэлбэр буюу үсэг үеийн тогтолцоо нь монгол хэлний үгийн бүтцийг олон зуун жил гайхалтай хадгалж ирсэн. Үүнийг гүйцэд ухаж ойлгоогүйгээс болж монгол бичгийг өөнтөглөх бас нэг шалтгаан гарч ирдэг. Энгийн үгээр хэлбэл, фото зураг дээр гарсан арван хүн бүгд нэг царай дүрстэй байна гэвэл утгагүй биз ээ. Түүний адил монгол хэлний үг болгон үгийн сангийн утга, авианы бүрхүүл өөрчилөгдөж ирсэн түүхтэй, тэр нь хэлний хууль юм бол өөрийн гэсэн хэлбэртэй байх ёстой. Эдүгээ шууд хэлэхэд шинэ үсгийн балагаар монгол хүн, хүний бичсэн төдийгүй өөрийн бичсэн зүйлээ ойлгохгүй болчихсон байна. Орчин цагийн монгол хэлээр “*хутга, хөрөө, хялгас, хумс*” гэж бичээд “*хутга, хөрөө*” гэхэд “*зүсдэг, хэрчидэг, тайрдаг*” хэмээсэн дохио төгс биш юм аа гэхэд харьцангуй сэтгэгдэж байхад нэг язгууртай “*хялгас, хумс*” гэдэг үг, уг ёсоороо бол бас л “*зүсдэг, хэрчидэг, тайрдаг*” гэсэн дохио дотоод хэлбэрийн хувьд монгол хүнд сэтгэгдэж байх ёстой атал тийм биш болжээ. Тэгвэл бид монгол бичгээ халаагүй хэрэглэсээр ирсэн бол дээрх дөрвөн үгийн дуудалга яаж ч өөрчилөгдсөн “*ki-*” гэсэн нэг язгууртай, үгсийн сангийн “*зүсдэг, хэрчидэг, тайрдаг*” хэмээх цөм утга илтгэдэг гэж монгол хэлний дотоод хэлбэрээс үүдэн монгол хүн ойлгох байсан.

Гэхдээ орос бичиг үсэг, хэл соёл үүнд ямар ч буруугүй. Түүхийн тодорхой нэгэн цаг үед бусдын дарамт шахалтаар харь хүний зөвхөн өөрт нь тохирдог үсэг бичгийг нь авч хэрэглээд түүнийгээ халж орхиж чадаагүй нь бидний л гэм. Монгол хэлний зүйн тухайд ч байдал мөн ижил. Нэгэнт европ зүгийн хэл шинжээчид энэтхэг-европ хэлний зүйгээ дор хаяж XIV зуунаас нааш боловсруулахдаа хожим тэдний нугархай хэлэнд тохирдог хэлзүйгээр залгамал хэлнүүдийг судална хэмээн яахин тооцоолсон байх билээ.

#### РЕЗЮМЕ

Данная проблема затрагивалась учеными монголооведами, с того момента, как была принята в Монголии новая письменность, основанная на кириллице и, до сих пор является спорным и не решенным вопросом в области монголоведения. В данной статье, мы вкратце, высказали свои мнения в защиту старомонгольской письменности, которую не в состоянии заменить ни одно другое письмо. Новое же письмо, основанное на кириллице отрицательно влияет на орфографию, орфоэпию монгольского языка, и тем самым и на мышление монголов.

**НОМЗҮЙ**

1. Владимирцов Б.Я. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Введение и фонетика. Л., 1929.
2. Грайворонский В.В. Вклад монголоязычных народов в мировую цивилизацию. История и культура народов Центральной Азии. Улан-Удэ, 1993.
3. Гюстав Гийом Принципы теоретической лингвистики. М., 1992.
4. Дондуков У.-Ж.Ш. Словообразование монгольских языков. Улан-Удэ 1993.
5. Доржсамбуу О. Тод монгол үсгийн бичгийн хэлний тойм. Осака, 2005.
6. Орловская М.Н. Имена существительные и прилагательные в современном монгольском языке. М., 1961
7. Рассадин В.И. Местоимения в монгольских языках // Вопросы грамматики монгольских языков. Новосибирск, 1991.
8. Санжеев Г.Д. Современный монгольский язык. М., 1959.
9. Санжеев Г.Д. Сравнительная грамматика монгольских языков. М., 1964.
10. Тодаева Б.Х. Грамматика современного монгольского языка. Фонетика и морфология. М., 1951. 188 с.
11. Трофимова С.М. Именные части речи в монгольских языках. Улан-Удэ, 2001.
12. Дашцэдэн Т Орчин цагийн монгол хэлний нэрийн тоо. (Эрдэм шинжилгээний бүтээл) УБ., 1981.
13. Лувсанвандан Ш. Орчин цагийн монгол хэлний бүтэц. (Үг нөхцөл хоёр), УБ., 1968.
14. Лувсанжав Чой. Сопоставительный анализ морфологической структуры слова в монгольском и английском языках. М., 1971.
15. Өнөрбаян Ц. Орчин цагийн монгол хэлний үгзүй. УБ., 1995.
16. Өнөрбаян Ц. Монгол хэлний үг бүтэх ёс. УБ., 1978.
17. Ринчен Б. Монгол бичгийн хэлний зүй. Дэд дэвтэр. (Авиан зүй) УБ., 1966.
18. Ринчен Б. Монгол бичгийн хэлний зүй. Дөтгөөр дэвтэр (Өгүүлбэр зүй) УБ., 1967.
19. Төмөртоогоо Д. Монгол хэлний түүхэн хэлзүй. УБ., 1995.
20. Шагдарсүрэн Ц. Монгол үсэгзүй. УБ., 1981
21. Шагдарсүрэн Ц. Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 1991
22. Шагдарсүрэн Ц. Монголчуудын үсэг бичгийн товчоон. УБ., 2001.

